## V.ДАЯАРЧЛАЛ

**<u>Даяарчлал гэж юу вэ, чухам юу вэ? Энэ нь мэдээлэл холбооны технологитой ямар холбоотой вэ?</u>**

Зам тээврийн хэрэгсэл, зөөвөрлөн хүргэх үйлчилгээ, утсан холбоо, хэвлэл мэдээллийн хэрэгсэл гээд л, энэ бүхнээс эхлээд техник технологийн дэвшил нь уудам өргөн дэлхий ертөнцийг ч жижигсгэн жижигсэгсээр нэгдмэл нэгэн цогц болгож байна. Харин одоо мэдээлэл холбооны технологи нь улам бүр жижиг, илүү нэгдмэл болгож байна.

Улс хоорондын хил хязгаарыг үл харгалзан харилцаа холбоо, худалдаа наймаа, ажилд авах процесс, хувь хүмүүсийн болон улс хоорондын бизнес гэрээ хэлэлцээр дэлхий нийтийн хэмжээнд явагдаж байгаа билээ.

Нобелийн шагналт Стиглиц даяарчлалын тухай тодорхойлохдоо

... тээвэр холбоо зэргээс гарах зардлыг асар ихээр хэмнэн дэлхийн хүн ард, улс орнуудыг ойртон нэгтгээд зогсохгүй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, мэдлэг зэргийг хил хязгаар үл харгалзан орж ирэхэд хаалт болж байсан зохиомол саад бэрхшээлийг устгасан юм[1] гэжээ

Даяарчлал нь зөвхөн эдийн засгийн үзэгдэл биш, хүн төрөлхтний амьдралын бүхий л салбарт тусгалаа олж буй билээ.

Дараах дөрвөн хүчин зүйл даяарчлагдахад нөлөөлсөн гэж үздэг байна. Үүнд: 1) технологийн шинэчлэлт тэр дундаа МХТ-ийн хувьсгал; 2) зах зээлд суурилсан эдийн засгийн тогтолцооны тархалт; 3) улс төрд даяарчлалыг дэмжигч хүчнийхний нөлөө ихэссэн явдал болон ; 4) улс доторх сөргөлдөөн[2] зэрэг орно

**<u>Даяарчлал үндэстэн улсад хэрхэн нөлөөлөх вэ?</u>**

Энтони Жиддэнс дараах 3 байдлаар нөлөөлнө[3] гэжээ. Нэгдүгээрт, улс үндэстэн эдийн засгийн ирээдүйгээ хянаж чадахаа байж дэлхийн зах зээлээс нэлээд хэмжээгээр хамааралтай болно. Үүнийг тухайн нэг улсын валютын ханш нь бусад орнуудын тус улсын эдийн засагт өгч буй үнэлэлтээр тодорхойлогддог болсон байгаагаас харж болно. Тэрээр цааш нь, даяарчлал улс доторх үндэстэнүүд соёл, ёс заншлаараа тусгаарлан ялгаран автономит болох боломжийг нээж өгч байгаа бөгөөд даяарчлагдах тусам нутгархах салан тусгаарлах байдал ажиглагдаж байна.

Даяарчлалын үзүүлж буй 3 дахь нөлөө нь бүс нутгийн бүлэглэлүүдийг бий болгож буй явдал юм. Үүнийг Кеничэ Охмаэ "бүс нутгийн мужууд"[4] гэж гэж тодорхойлсон бөгөөд Жиддэнс, Охмаэ 2 хоёулаа Хойд Испанийн Барселон хавийн Каталон мужийг жишээ болгон авчээ. Каталон нь Испаниас эдийн засгийн хамааралтай ч Францтай мөн ёс заншил угсаатны зүйгээр холбоотой юм

Эцэст нь даяарчлал нь хоорондоо зөрчилдөөнтэй хүчнүүдийн нэгдмэл цогц билээ.

**<u>Интернет болон МХТ ийн хувьсгал засаглалд хэрхэн нөлөөлөх вэ?</u>**

Засаглалыг "хамтын үйл ажиллагааг зохион байгуулагч"[5] гэж энгийнээр нэрлэж болох юм. Эндээс тодорхой нэг үйл ажиллагааг зөвшөөрсөн, хориглосон эсвэл заанч иглүүлсэн дүрэм журмыг гаргаж байдаг. МХТ нь засаглалд их нөлөөтэй. Канадын Засаглалын хүрээлэнгээс МХТ ийг тодорхойлохдоо:

... МХТ нь иргэдэд засгийн газрын үйлчилгээ хэрхэн тэдэнд хүрэх болон засгийн газартай хэрхэн харилцан нөлөөлцөж болох талаар шинэ хүлээлтийг бий болгодог. Интернетийн технологи, генетикийн шинжлэх ухаанд сүүлийн үед гарсан олон амжилтууд нь олон нийтэд хамаатай асуудлаар хувийн болон хамтын шийдвэр гаргахдаа төвөгтэй үзэх хүрээг тэлж байна[6].
Засгийн газрын үйлчилгээг ард иргэдэд хүргэнүүг нөлөөг нэмэгдүүлэхэд МХТ-ийг хэрэглэснээр засаглал бүр сайжрах бөгөөд цахим засгийн газар нь сайн засаглалыг хэрэгжүүлэх зайлшгүй нэг

---

[1] Joseph E. Stiglitz, Globalization and its Discontents (NewYork: Norton& Company, 2002), 9.
[2] Aseem Prakash and Jeffrey A. Hart, "Globalization and Governance: An Introduction", in Aseem Prakash and Jeffrey A.Hart (eds.), Globalization and Governance (London: Routledge, 1999), 5.
[3] Giddens, "Runaway World", 6.
[4] Kenichi Ohmae, The Invisible Continent:Four Strategic Imperatives of the New Economy (New York: HarperBusiness, 2000).
[5] Prakash and Hart, Globalization and Governance, 2.
[6] Institute on Governance, "Technology and Governance", http://www.iog.ca/knowledge_areas.asp?pageID=6&area=4; 2002 оны 8 сарын 31-нд хандсан

элемент болох юм Цахим засгийн газар нь хамгийн үр нөлөөтэйгээс гадна хамгийн ил тод нь байх болно

**Мэдээлэл холбооны технологи олон улсын улс төрийн амьдралд хэрхэн нөлөөлж байна вэ?**

Роберт Кеохан болон Жозеф Най нарын эрдэмтэд мэдээллийн эрин зууны улс үндэстнүүдийн хоорондын харилцааг үндсээр нь өөрчилнө гэдэгтэй санал нийлэхгүй байгаа ажээ. Учир нь улс орнууд нийгэм болон улс төрийн олон талт харилцаагаар хоорондоо холбогдож бие биенээсээ нэгэнт харилцаа хамааралтай болсон[7] гэж тэд үзэж байна,

Мэдээллийн хувьсгал нь дэлхийн улс төрийн – засгийн газрын тогтолцоон дахь хувь хүмүүс хоорондын төдийгүй сүлжээн дэх хүмүүсийн хоорондын харилцах сувгийг нэмснээрээ харилцан хамаарлын хэв маягийг өөрчилж байна гэж тэд хэлж байгаа бөгөөд энэ харилцан хамаарал нь орчин үеийн улс төрийн тогтолцооны нэг шинж бөгөөд мэдээлэлд ихээр нөлөөлдөг[8],

Түүнчлэн тэд 21-р зуунд мэдээллийн технологи нь өргөн тархаж, хамгийн хүчирхэг салбар болно гэдэгтэй санал нэгтэй байгаа юм

Өөр бусад эрдэмтэд nooploitik –ийн онолыг дэвшүүлээд байгаа бөгөөд энэ нь дэлхийн мэдээллийн хүрээлэл буюу noosphere дахь олон харилцааны хэм хэмжээг тогтоохыг хэлж байгаа юм

Nooploitik нь тухайн нэг улсын хүч чадал эрх мэдлийг олон улсын тавцан дээр гэрээ хэлэлцээр хийх эсвэл хүч хэрэглэх замаар өсгөхөд чиглэгдсэн realpolitik-ийн өөр нэгэн хувилбар болон гарч ирсэн Мэдээлэл ба харилцаа холбооны хэлбэржин даяаршлагдан буй ертөнцөд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон бусад эх сурвалжуудаас урсан орж ирж буй мэдээллийг боловсруулан хэрэглэх чадвар нь улс төрийн алив асуудлыг шийдвэрлэхэд туслах гол зэмсэг болж байна[9].

Nooploitikт засгийн газрыг түүний төлөөлөн буй нийгэмтэй нь бүхэлд нь авч үздэг. Энэ шинэ дипломат ёс нь сөргөлдөөнөөс зайлсхийх, холбоод болон нэгдэх, улс төрийн, соёл давуу байдлыг нэмэгдүүлэхэд тустай. Үндэстний хэмжээний улс төрийн нийтлэг зан авир хийгээд олон нийтийн далд санаа бодолд хөндлөнгөөс нэвтрэн орох чадвартай[10] юм

**Кибер дайн гэж юу вэ? Энэ нь мэдээллийн дайн болон кибертерроризмтай адил уу?**

Жеймс Данниганы тодорхойлсноор, кибер дайн нь мэдээлэл болон цахим сүлжээг зэвсэг болгон ашиглах[11] ажээ. Энэ дайнд, дайсныхаа банкны данс тооцоо, толгой компьютер, мэдээллийн сүлжээ рүү нууцаар нэвтрэн орж пуужингаа радарт нь баригдалгүйгээр харвах цэргийн онгоц бий. Тэрээр кибер дайныг мэдээлэл, мэдээг зэвсгээ болгон ашигладаг мэдээллийн дайнаас ялгаатай юм гэжээ. Мэдээллийн дайн буюу суртал ухуулгын дайн нь Данниганы хэлж буйгаар хэдэн мянган жилийн тэртээгээс байсаар иржээ. Кибертерроризм нь үндэстний цөөнх эсвэл нууц тагнуулуудын компьютерийн сүлжээ, программ өгөгдөл зэрэг үрүү рүү хийж буй нарийн зохион байгуулалттай улс төрийн шинж чанартай дайралт юм[12] гэж тодорхойлж болно
Энэ нь олонхи пүүс компаниуд болон засгийн газрууд бүхий л нууц чухал баримт мэдээллээ компьютерт хадгалах, нэг үгээр хэлэхэд компьютерээс бүрэн хамаарах болсонтой холбогдон гарах болсон үзэгдэл юм Нислэг, банк санхүүгийн данс тооцоо, ус ашиглалт, болон нийгмийн бусад салбаруудын бүхий л асуудлуудыг компьютерийн программ сүлжээний тусламжтайгаар хянан зохицуулж байх болжээ. Тиймээс л энэхүү тогтолцоо, сүлжээ нь ямарваа улс орны засгийн газар, эдийн засгийг заналхийлэх сонирхолтой хүмүүсийн гол бай нь болоод байгаа юм

**Кибер хамгаалалт гэж юу вэ?**

---

[7] Robert O.Keohane and Joseph S. Nye, Jr., “Power and Interdependence in the Information age” Foreign Affairs 1998 оны 9/10 сар, http://www.cis.washington.edu/courses/winter02/sis410/syllabus/week2/nyekeohane_fa_1998.pdf

[8] Ibid.

[9] Castells, The Internet Galaxy, 160.

[10] John Arquilla and David Ronfeldt, The Emergence of Noopolitik: Toward an American Information Strategy (Santa monica, CA: RAND National Defense Research Institute, 1999).

[11] James F.Dunnigan, the next War Zone: Confrontingthe Global Threat of Cyberterrorism (New York: Citadel Press, 2002),2.

[12] Mark M. Pollitt, “Cyperterrorism – Fact ir Fancy?”; http://www.cs.georgetown.edu/`denning/infosec/pollitt.html, 2002 оны 8 сарын 8-нд хандсан

Кибер орон зай дахь заналхийлэл сүрдүүлэг зэрэг гэмт хэргийн эсрэг тэмцэхийг кибер хамгаалалт гэнэ. Үүнд зөв зохистой бодлого , хууль болон залилан, аюул заналаас сэргийлэх мэргэжсэн байгууллага зэргийг байгуулах орно

Улсын хэмжээнд засгийн газраас зөв зохистой бодлого боловсруулж хууль зүйн орчинг бүрдүүлэх, шийдвэрлэх дэд бүтцийг кибер дайралтаас хамгаалах, улсын мэдээллийн системийн хамгаалалтыг сайжруулах тал дээр кибер хамгаалалтаа улам боловсронгуй болгохоор гол анхаарлаа хандуулаад байна. Харин дэлхийн хэмжээнд кибер дайралтаас хамгаалах дэлхий нийтийн маш боловсронгуй нэгдсэн системтэй болохоор, тун уян хатан бодлогыг боловсруулан хэрэгжүүлж байгаа билээ.

НҮБ-ийн 2002 оны 12-р сард хуралдсан нэгдсэн чуулганаар

“Дэлхийг хамгаалах зам[13]” буюу 57/239-р тогтоолыг гаргасан. Харин Ази Номхон далайн бүс нутагт , Ази Номхон Далайн Хамтын ажиллагааны орнуудын тэргүүлэгчид “Терроризм болон түүний гаралттай тэмцэх тухай тогтоол” / үүнд АСЕАН-ы орнууд, мэдээллийн сүлжээг хамгаалах кибер хамгаалалтын бодлогыг тусгасан болно/ -ыг боловсруулан гаргасан.

Уг тогтоолд Ази Номхон Далайн Хамтын Ажиллагааны Орнуудын удирдагчид төлөвлөгөөгөө[14] танилцуулсан байна. Үүнд:

1. Олон улсын хэмжээнд нийцсэн кибер хамгаалалтын хуулийг боловсруулах
2. Улс дотоодох кибер гэмт хэргийн нэгжүүдийг тогтоох
3. Компьютерийн болзошгүй аюулуудаас сэрэмжлүүлсэн мэдээллүүдийг солилцох хүрээлэнг байгуулах / компьютерийн тусламжийн багтай ижил /

Кибер хамгаалалтаа чангатгах нь чухал хэдий ч шинжээчид кибер террористуудийн дайралтыг зогсоох аргагүй юм гэж үзэж байгаа юм. Яагаад гэвэл терроризм нь яг л аянга мэт хүчирхэгжих тусам дайралт нь ширүүсдэг. Түүнчлэн, өнөө үед компьютерийн системд гэмтэл учруулахаас илүүтэйгээр түүнийг шууд усгачих нь илүү хялбар хэрэг юм

[13] http://un.org/Depts/dhl/resguides/57.htm

[14] http://www/apecsec.org.sg/download/pubs/LeaderStmtFightTerroNGrowth.pdf